



ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ, ВИДЕО ШТОРК, ЗУРАГТ ПОСТЕР,  
ШУУД ДАМЖУУЛАЛТ, ХИЙХЭД ШААРДАГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Тендерийн нэр:** Онцгой комиссын цаг үеийн мэдээ мэдээлэл, шууд дамжуулалт, видео хийх.

#### Тендерийн дугаар:

Техникийн шаардлагын тодорхойлолтод заасны дагуу нотлох баримтуудыг ирүүлнэ.  
Видео шторк, зурагт постер, арга хэмжээний дараах төрлүүдээр тус бүр 1 бүтээл ирүүлнэ.  
Дээрх төрлийн дүрслэлийг гүйцэтгэх мэргэжлийн ур чадварын ажилтантай байна. Таваас дээш жил телевизийн салбарт ажилласан туршлагатай мэргэжлийн боловсон хүчинтэй байна.

Үндэсний хэмжээний хурал зөвлөгөөн, арга хэмжээ, үйл ажиллагаатай холбоотой контент бүтээж байсан туршлагатай байх. /Бүтээлээ хавсаргах/

Үүнд: Мэргэжлийн сэтгүүлч заавал байх. Гэрээт зураглаач, найруулагч байна.

Компанийн дэлгэрэнгүй танилцуулга, мэдээ мэдээлэл, видео шторк, зурагт постер хийх үйлчилгээтэй холбоотой техникийн шаардлагад заасан холбогдох мэдээллийг ирүүлнэ.

Мэргэжлийн тоног төхөөрөмжтэй байх.

### ТЕХНИКИЙН ШААРДЛАГА ТОДОРХОЙЛОЛТ

#### Ерөнхий мэдээлэл

Тодорхой сэдвийн хүрээнд видео бичлэг хийх, фото зураг авах, цаг үеийн мэдээ, шторк, зурагт постер, видео эвлүүлэг, шууд дамжуулалтуудыг тус тус хийнэ.

Улсын Онцгой комисс, нийслэлийн Онцгой комисс, дүүргийн Онцгой комиссын зүгээс хийж хэрэгжүүлж буй ажлууд, Короновируст халдврын эсрэг хэрэгжүүлж буй хариу арга хэмжээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилготой цаг үеийн мэдээ, видео шторкыг FULL HD болон 4K өргөтгөлөөр мэргэжлийн төвшинд хийх.

Цаг үеийн үйл ажиллагаатай холбоотой шууд дамжуулалтыг хөдөлгөөнт байдлаар газар дээрээс нь хийх.

Фото зураг авалт хийх, Сээрэмжлүүлэг, Зөвлөмж, Мэдээ мэдээллийг зурагт постер хэлбэрээр тухайн сэдвийн хүрээнд ойлгомжтой байдлаар мэргэжлийн төвшинд хийж гүйцэтгэх.

#### Дүрслэл, дуу хоолой, хөгжим, зураг

Шторкууд нь дүрслэлийн хувьд HD, 4K өргөтгөлтэй видео дурс, time lapse, хөдөлгөөнт инфографик, 2D/3D график модель дүрслэл болон эдгээрийн хосолсон дүрслэлтэй байна. Тодруулбал, тухайн сэдвийг харуулах хамгийн оновчтой дүрслэлийн (хосолмол байж болно) аргыг сонгоно.

Дуу хоолойн хувьд тухайн мэдээ, шторкын текстийг агуулгад нийцсэн хэв маягаар унших ба агуулга ойлгомжтой, сонсголонтой сонсогдохоор унших, ур чадвартай, мэргэжлийн хүний олонд танигдсан хоолой байна.

Шторкод ашиглах хөгжим, дуу, ая болон дүрсүүд зохиогчийн эрхийн зөрчилгүй байх.

**Онцгой комиссын цаг үеийн мэдээ мэдээлэл, шууд дамжуулалт , видео хийх ажил гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:**

Тухайн студи харьяалагдаж буй компани, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд:  
1821 -Дуу, дүрс бичлэг хийх,  
59110 -Уран сайхны болон баримтат кино хийх үйл ажиллагааны чиглэл тус тус бүртгэгдсэн байх.

Мэргэжлийн техник, тоног төхөөрөмжтэй байх.

Үүнд:

- 1.Мэргэжлийн видео камер- 1 ш
- 2.Мэргэжлийн фото аппарат -2 ш
- 3.Эвлүүлэг хийх өндөр үзүүлэлт бүхий суурин компьютер -2 ш
4. Дрон -1 ш
- 5.Микрофон -3 ш
- 6.Бусад дагалдах техник хэрэгслүүд./Студийн лед гэрэл, камериийн хөл /tripod/

#### **Мэргэжлийн туршлагатай боловсон хүчинтэй байх**

Таваас дээш жил телевизийн салбарт ажилласан мэргэжлийн туршлагатай сэтгүүлчтэй байх. Гэрээт зураглаач, найруулагч, эвлүүлэгчтэй байх.

Мэргэжлийн сэтгүүлчийн CV-г ирүүлэх, мэргэжлийн дипломын хуулбар хавсаргах. Ажилтан тус бүрийн CV-г ирүүлэх.

Долоо хоногийн ажлын цагаар тухайн гүйцэтгэх ажил дээрээ 2-3 хүнтэй баг байнга ажиллах.

Үргэлжлэх хугацаа 2024 оны 03 дугаар сарын 01-ээс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх байна.

/Амралтын өдрүүдэд шаардлагатай тохиолдолд 2 хүн ажиллах боломжтой байх/  
2022-2023 онуудад бүтээсэн уран бүтээлүүдээс телевизээр, болон сошиалд цацагдаж олонд хүрсэн бүтээлүүдээс багадаа 2 бүтээлийг ирүүлэх. (CD/DVD, флаш, хард-д бичиж ирүүлэх, үзэх холбоос хавсаргах)

Олон нийтэд хүрсэн 10-аас дээш бүтээлтэй байх. Уг бүтээлүүд нь Телевиз, Youtube, Facebook зэрэг сувгуудаар цацагдсан байх /үзэх холбоосыг ирүүлэх/.

№	Хийх ажлын нэр	Хугацаа	Тоо хэмжээ	Хэмжих нэгж
1.	Видео Шторк  Шторкууд нь HD, 4K видео дүрс, time lapse, хөдөлгөөнт инфографик, 2D/3D график модель дүрслэл болон эдгээрийн хосолсон дүрслэлийг ашигласан ойлгомжтой байдлаар хийгдсэн байна.	40-60 Секунд	80	ш
2.	Зурагт постер хийх  Сэргэжлүүлэг, Зөвлөмж, Мэдээ мэдээллийг зурагт постер хэлбэрээр	JPG  JPEG	300	ш

	тухайн сэдвийн хүрээнд ойлгомжтой байдлаар мэргэжлийн төвшинд хийж гүйцэтгэх.	RAW 148x210		
3.	Шууд дамжуулалт /live/  Мэргэжлийн камераар хөдөлгөөнт байдлаар тухайн үйл явдал болж буй газар дээрээс нь дуу, дүрсний өндөр чанартайгаар шууд дамжуулалт гүйцэтгэх.	30+Минут	30	ш
4.	Нөлөөллийн контент  Гамшгаас урьдчилан сэргийлэх, Халдварт өвчин, Хүүхэд хамгаалал, Архигүй орчин бүрдүүлэх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвээр контент бэлтгэх.	10-20 минут	30	ш
5.	Цаг үеийн мэдээ  Тухайн мэдээ, мэдээллийг телевизийн шаардлагад нийцүүлэн, эхлэл шторк, закадр, яриа, тексттэй түргэн шуурхай хийж гүйцэтгэх.	1-4 минут	80	ш
6.	Фото зураг авалт хийх  Тухайн үйл явдлын хүрээнд мэргэжлийн фото зураг авалт хийж гүйцэтгэх.	JPG RAW 210x297	300	ш

ХЯНАСАН:

Онцгой байдлын хэлтсийн дарга

БОЛОВСРУУЛСАН:

Онцгой байдлын хэлтсийн орлогч



Д.Бат-Эрдэнэ



Б.Батбаяр